

НИЙГМИЙН АЖИЛ-НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХАМГААЛАЛ

АХМАД НАСТАН ХОРИГДОЛТОЙ АЖИЛЛАХ НИЙГМИЙН АЖЛЫН ПРАКТИК, ЦААШИД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

*Н. Нямдорж
Доктор (Ph.D.)*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

nyataa89@gmail.com

*Г. Батжаргал
Докторант*

*Дотоод хэргийн их сургууль
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль*

jagaajambaa@gmail.com

Хураангуй: Энэхүү илтгэлээр хорих ял эдлүүлэх ажиллагааны онцлог чиглэл болох хорих ял шийтгүүлсэн ахмад настай хоригдолд үзүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдаж буй зарим асуудал, нийгмийн ажлын үйлчилгээнийг сайжруулах талаар судалгаанд суурилсан санал дэвшүүлэхийг зорих юм.

Түлхүүр үгс: Хорих ял, ахмад настан, хоригдол, нийгэмшүүлэх ажил, нийгмийн ажлын үйлчилгээ

УДИРТГАЛ

Дэлхийн ихэнх улс орнуудын хөгжлийн бэрхшээлийн статистикийн уламжлалт чиг хандлага хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог тодорхойлоход чиглэгдэж байсан бол сүүлийн үед уг үзэл санаа өргөжин тэлж, тэдгээрийн нийгмийн харилцаанд оролцоход тулгарч буй өдөр тутмын хүндрэл, бэрхшээлийг илрүүлэх, шалтгааныг нарийвчлан судлах, хэрэгцээг тодорхойлох зэрэг өргөн агуулгаар хөгжиж байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь хөгжлийн бэрхшээлгүй иргэдтэй адил нийгмийн харилцаанд эрх тэгш оролцож, тэдгээртэй ажил хөдөлмөр эрхэлж, ижил хөлс авах зэрэг үзэл санаанд үндэслэн хөгжиж байна.

Энэхүү илтгэлээр манай улсын хэмжээнд гэм буруутай нь тогтоогдож шүүхээр ял шийтгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй хэдэн хоригдол хорих ял эдэлж байгаа, хуулиар олгогдсон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийг авахтай холбоотой эрх зүйн орчин нөхцөл бүрэлдсэн эсэх, хорих ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдал, тэдэнд тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, тэдний нийгмийн харилцаанд эрх тэгш оролцох, хөгжих эрхийн талаар судалж, үр дүнтэй саналыг дэвшүүлэхийг зорилгоо.

Судалгааны хамрах хүрээ: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хорих ялаар шийтгүүлсэн ахмад настай хоригдол, тэдэнд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж буй нийгмийн ажилтан нарын мэргэжлийн үйл ажиллагааг хамруулан судална.

Судалгааны зорилго: ахмад настай хоригдлын өнөөгийн байдал тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг тодорхойлж, судалгаанд үндэслэн тэдний эрхийг хангахад чиглэсэн санал дэвшүүлэх,

Судалгааны зорилт:

- Ахмад настай хоригдлын эрх зүйн байдлыг судална,
- Ял эдлүүлэх ажиллагааны онцлог, орчин нөхцөл, онцлог хэрэгцээ шаардлагыг судална,
- Тэдний нийгэм, сэтгэл зүй, хүний эрхийн асуудлыг судална,

Судалгааны таамаглал:

Ахмад настан хоригдлыг ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хувь хүний ялгаатай байдал, орчин нөхцөл бүрэлдээгүй байгаагаас үүдэлтэй тэдний хүний эрхийн асуудал зөрчигдөж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар нь ахмад настантай ажиллах онол, арга зүйн мэдлэг, дутмаг байгаагаас тэдэнд үзүүлэх нийгмийн ажлын болон нийгмийн халамжийн үйлчилгээ хүртээмжтэй, үр дүнтэй байж чадахгүй байна.

Судалгааны арга: Анкетын арга, статистик, кейс судлал

Судлах зүйл: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль бусад дүрэм журам, хорих анги, шийдвэр гүйцэтгэх газрын нийгмийн ажилтан нарын мэргэжлийн үйл ажиллагаа, ахмад настан хоригдол,

Судалгааны шинэлэг тал: Тухайн сэдвийн хүрээнд өмнө нь судалгааны ажил хийгдэж байгаагүй ба судалгаанд үндэслэн асуудлыг хууль, дүрэм журам, бодлогод тусган шийдвэрлүүлэх саналыг дэвшүүлж байгаагаараа, мөн нийгмийн ажлын практик үйлчилгээний үр дүнг нэмэгдүүлэх, цаашид учирч болох эрсдэлийг тооцож, үйл ажиллагааг чиглүүлж байгаагаараа ач холбогдолтой, шинэлэг гэж үзэж байна.

ОНОЛ, АРГА ЗҮЙ

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй ахмад настны нийгмийн хамгаалалд хамрагдана гэж үздэг.⁷ Ахмад настуудад үзүүлж буй нийгмийн хамгааллын үйлчилгээ нь тэдний хэвийн амьдрах нөхцөлд анхаарч, ахмадуудын харьяалагдаж буй гэр бүл, нийгэмдээ дасан зохицох, нэгдэхэд нь шаардлагатай дэмжлэг үйлчилгээ үзүүлэх, хэрэглэгдэх эд материал, хүн хүчний нөөцийг хайх, тэдгээрийг холбох, хангах, нийгмийн дасан зохицолтой холбоотой асуудлыг шийдвэрлэх, цаашлаад хувь хүний хөгжил, хэрэгцээнд шаардлагатай үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой төрийн болон төрийн бус байгууллагын авч хэрэгжүүлж буй мэргэжлийн үйлчилгээ, үйл ажиллагаа байдаг.

Ахмад настай хорих ял шийтгүүлсэн хоригдолд нийгмийн ажлын зарим үйлчилгээ нь дээрх агуулгыг хангахад чиглэгдэнэ. Тодруулбал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 210 дугаар зүйлийн 210.1.8-д хоригдол урьд тогтоолгосон тэтгэвэр, тэтгэмжээ үргэжлүүлэн авах, хуульд заасан болзол шаардлагыг хангасан тохиолдолд хуулиар тогтоосон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох эрхтэй⁸ гэж заажээ.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан ахмад настай хоригдолд үзүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээний өнөөгийн байдал:

Хорих ял шийтгүүлсэн ахмад настай хоригдлыг тус хорих ангид хүлээн авснаас хойш нийгэмд суллагдан гарах хүртэл буюу хоригдох хугацаанд нь зан үйлд нөлөөлөх, амьдрах ухааны, хүмүүжлийн эерэг нөлөө үзүүлэх сургалтуудад хамруулдаг.

Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар ганцаарчилсан уулзалт хийж, байгууллагын дотоод журам, хоригдлын эрх үүргийг тайлбарлах, ар гэрт нь мэдэгдэх, тэдний сэтгэл санааны байдлыг тодорхойлж, сэтгэл зүйн болон бусад тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн нийгмийн ажил, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг.

Мөн ахмад настай хоригдлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, тэдний онцлогийг харгалзан сургалтад хамруулах, сэтгэл зүйн сорил авах, тэдэнд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулдаг.

Хорих ангид нь ахмад настай хоригдлуудад хүмүүжлийн эерэг нөлөө үзүүлэх, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдрах ухаанд сургах зорилгоор төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг.

⁷ Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль

⁸ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

Нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид, байгууллагын зүгээс хоригдлын үйлдсэн гэмт хэргийн гэмт хэрэг, хувийн зан байдлын онцлогийг харгалзан “Уур бухимдалаа зохицуулах” хөтөлбөрт сургалт “Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх нь” сургалтуудыг тогтмол хуваарийн дагуу зохион байгуулж, тэдний засрал хүмүүжил олж хугацаанаас өмнө суллагдах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зэрэгт чухал ач холбогдолтой бөгөөд нийгмийн амьдралд эргэн орох, дахин алдаа гаргахгүй байхад тус дэм болдог. Мөн суллагдах дөхсөн хоригдлыг бичиг баримтжуулах, иргэний бүртгэлд хамруулах ажлыг орон нутгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран зохион байгуулдаг.

Ахмад настай хоригдлын гэр бүлийн эерэг харилцааг хадгалах, гэр бүл, нийгэмтэй ойр байлгах, суллагдан гараад гэр бүлийнхээ дэмжлэгийг авч хэвийн амьдрах нөхцлийг хангах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулдаг.

Суллагдан гараад очих гэр оронгүй, хүлээж авах орон гэргүй хоригдлуудад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зуучлалын үйлчилгээ үзүүлэх зэрэг нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг байна.


Тухайн өндөр настай хоригдлын урьд тогтоолгосон тэтгэвэр, тэтгэмжээ үргэжлүүлэн авах, хуульд заасан болзол шаардлагыг хангасан тохиолдолд хуулиар тогтоосон тэтгэвэр, тэтгэмжид шинээр харуулдаг.

Олон улсын ахмадын баярын өдөр, цагаар сарын баярын өдрүүдэд хорих ангийн нийгмийн ажилтан нарын санаачилгаар ахмад настай хоригдолд гарын бэлэг гардуулах зэрэг ажил үйлчилгээг зохион байгуулж байна.

СУДАЛГАА

Өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд нийт 140 орчим өндөр настай хоригдол хорих ял эдэлж, нийгмийн ажлын үйлчилгээнд хамрагдаж байна.⁹

Зураг 1. Ахмад настан эрэгтэй, эмэгтэй хоригдлын тоо




Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

⁹ ШШГЕГ-ын 2022 оны 4 улирлын тоон мэдээ

Хорих ял эдэлж буй ахмад настан хоригдлын 95% буюу 134 нь эрэгтэй, 5% буюу 7 нь эмэгтэй хоригдол байна.


Зураг 2. Ахмад настай хоригдлын ял эдлэх дэглэм, зэрэглэлээр нь авч үзвэл



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Хорих ангийн дэглэмээр авч үзвэл нээлттэй хорих ангид 78, хаалттай хорих ангид ял эдэлж байгаа 63 ахмад настан хоригдол байна.

Зураг 3. Өндөр настны тэтгэвэрт хамрагдах эсэх



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Судалгаанд хамрагдсан ахмад настан хоригдлуудын 26% буюу 30 гаруй нь бичиг баримтын бүрдүүлэлт дутуу, ар гэрийнхэн нь итгэмжлэл авч хөөцөлдөж амждаггүй, хорих ангийн нийгмийн ажилтны үйлчилгээ зөвлөгөө, мэдээллээр хангах, дэмжих, зуучлах үйлчилгээнд хамруулах зэрэг үйлчилгээ хангалтгүй байна.


Ахмад настан хоригдлуудаас нийгмийн харилцаанд оролцох эрхийн талаар асуулгын аргаар авсан судалгааны үр дүнг /зураг 4/ харуулсан байна. Тэд мэдээлэл авах, аливаад идэвхтэй оролцох, хөдөлмөр эрхлэх, боловсрол эзэмших, эрүүл мэндийн, сэтгэл зүйн үйлчилгээ авах эрх, боломжууд бага байдаг гэж үнэлсэн байна.

Зураг 4. Ахмад настай хоригдлын нийгмийн харилцаанд оролцох эрхийн талаар нь авч үзвэл



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Зураг 5. Өндөр настны гэр бүлийн харилцааг холбоог харуулав



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүй, ахмад настай хоригдол, иргэдээс нийгмийн ажлын үйлчилгээний талаар кейс судалгаа хийсэн ба дараах 5 кейсийг онцлов.

Кейс 1. Хорих ангийн нийгмийн ажилтан Б ахмад настай хоригдолд чиглэсэн тусгайлсан нийгмийн ажлын үйлчилгээний арга зүйг бол сайн мэдэхгүй байна. Гэхдээ тухайн хоригдлын онцлогт тохируулан нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлдэг. Тухайлбал ахмад настай хоригдлыг талбайн цэвэрлэгээ хийлгэх, цэцэг услах зэрэг хялбар ажилд хуваарьлан шагналын хоног олгох саналыг гаргадаг. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар ахмад настай хоригдлуудын өрөөнд нь очиж уулзах, ахмадын баяр болон цагаан сарын баяраар гарын бэлэг өгөх зэргээр тэднийг дэмжин ажилладаг.

Кейс 2. Хорих ангийн нийгмийн ажилтан Д ахмад настай хоригдлуудад эрүүл мэндийн үйлчилгээ түлхүү хэрэгцээтэй байдаг. Даралт өндөр, хууч өвчтэй өндөр настнууд их байдаг. мөн хоригдлын өмнө авч байсан тэтгэвэрээ үргэжлүүлэн авах, засгийн газраас өгч байгаа бусад мөнгөн тэтгэмжид харагдах хүсэлтүүдийг нийгмийн ажилтан нар шийдвэрлэн ажилладаг.

Кейс 3. Хорих ангийн сэтгэл зүйч Б ахмад настай хоригдлуудын сэтгэл зүйн байдлын хувьд зарим хоригдлууд сул дорой, өөртөө итгэлгүй байх хандлага байдаг. Тэдэнд бусадтай ярилцах хэрэгцээ их байдаг учраас сэтгэл зүйч нар тэдний яриаг сонсох нь чухал. Мөн сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилладаг.

Хорих ял эдэлж байгаа өндөр настай хоригдол болон суллагдан гарсан ахмад настанаас кейс судалгаа хийхэд тэдэнд дараах бэрхшээлүүд тулгардаг байна.

Кейс 4. Хоригдол Г нь 67 настай, анх удаагийн ял шийтгэлээр нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа. Хорих ангид ирээд нутгийн дүү нартай нэг өрөөнд хуваарьлагдах саналаа нийгмийн ажилтандаа хэлж, хамт орсон. Нутгийн 2 дүү маань их тус болж миний өмнөөс ярьж хэлж явдаг. Миний бие их өвддөг, сүүлийн үед сонсгол, хараа муудах болсон. Заримдаа 00 явахдаа бусад хоригдлуудаар түшүүлж явдаг. Яаж хэдэн жилийн ялыг эдлэнэ дэ, эндээ ясаа тавих байхдаа гэж бодож байна гэв...

Кейс 5. Би 2019 онд суллагдсан. Одоо 72 настай суллагдан гараад намайг хүлээж авах хүн байхгүй байсан тул шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагад хандан орон гэртэй болгох хүсэлт тавьсан боловч өөрийн гэсэн гэртэй болж чадаагүй. Харин байрны жижүүрийн ажил олж өгч ажлаа хийнгээ тэндээ амьдрах болсон. гэвч 2021 оноос хойш ажил хийх чадваргүй гэж ажлаас гарсан. Одоо очих газар, оочих хаяггүй тэнэмэл амьдралтай болсон. Заримдаа гэмт хэрэг хийж эргэн шоронд ордог ч юм билүү гэж боддог. Тэнд ядаж идэх хоолтой, дулаан байртай гэв...

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хорих ял эдэлж байгаа ахмад настанд нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэхэд анхаарах асуудал:

Хорих ял эдэлж байгаа ахмад настай хоригдолд нийгмийн ажилтан дараах чиглэлээр үйлчилгээ үзүүлэхээр холбогдох хууль, дүрэм журамд дараах байдлаар тусгасан байна. Үүнд: ахмад настай хоригдолд үзүүлж буй халамж үйлчилгээ нь эдийн засгийн баталгаагаар дэмжих /ШШГТухай хуулийн 210 дугаар зүйлийн 210.1.8-д заасан эрхтэй/, нийгмийн дасан зохицол, холбоо харилцааг нь дэмжих /ахмад настай хоригдлын гэр бүлд чиглэсэн үйлчилгээ, эргэлт уулзалт, харилцаа холбоог сэргээх/ хувь хүний хөгжих хэрэгцээ шаардлагыг үндэслэж ахмадуудыг дэмжих үндсэн зорилтод чиглэгдэнэ.

Хорих байгууллагын нийгмийн ажилтан нь ахмад настай хүнд илрэх бие мах бодийн болон сэтгэл зүйн онцлог нь өтөлснөөс болж бие махбодь, сэтгэл зүй, нийгмийн өөрчлөлтөө даган өөрийн онцгой ааш араншингийн байдлыг илтгэдэг, энэхүү өөрчлөлтийн шалтгаан нь бие махбодын хүчин зүйл, өнгөрсөн үеийн туршлагын хүчин зүйл, нийгмийн үйл ажиллагаа багассанаас болж үнэ цэнэ буурах, хүчгүй сул дорой

хэмээх бодлоос гарах, өндөр настанд хандах нийгмийн хандлага зэрэг нь онцгой нөлөөлдөг болохыг сайтар ойлгох нь чухал юм.

Өөрөөр хэлбэл ахмад настнуудад бусдаас ялгаатай дараах хэрэгцээнүүд үүсдэг. Нийгмийн зүгээс хүндлэгдэх хэрэгцээ, хаана хэрхэн амьдрахаа сонгох хүсэл, хэрэгцээ, биеийн тамир тэнхээ муудах, өвчин эмгэг туссан үедээ асруулж халамжлуулах хэрэгцээ, өндөр настай, өвчин эмгэгтэй хүн гэдэг утгаар бус харин хүний жам ёсны үүднээс хүлээж авахыг хүсдэг байна¹⁰.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь ахмад настай хоригдолд чиглэсэн халамжийн болон нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, бусад журамтай нийцүүлэн НҮБ-ын “Ахмад настны талаарх баримтлах зарчим” /1991/-д тусгагдсан дараах зарчмуудыг баримтлан ажиллах нь үйлчилгээг үр дүнтэй болгох ач холбогдолтой юм.

Хувь хүний бие даасан байдлыг харгалзах:

- Орлого, гэр бүлийн дэмжлэг, хоол хүнс, хувцас, эрүүл мэндийн хамгааллаар хангах
- Ажил хийх боломжоор хангах, бусад орлого олох нөхцлөөр хангах,
- Ажил хөдөлмөр эрхлэлтээс хэзээ хэрхэн болих талаарх шийдвэрт оролцох,
- Тохирох боловсрол, сургалт хөтөлбөрт хамрагдах боломж олгох,
- Хувь хүний сонголт болон аюулгүй, дасан зохицож чадах орчинд амьдрахад анхаарах,

Оролцоог хангах:

- хорих ангийн зүгээс зохион байгуулж буй олон талт үйл ажиллагаанд оролцуулах тухайлбал чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх спорт, урлаг, танин мэдэхгүйн тэмцээн уралдаан,
- Олон нийтийн оролцоотой байх, өөрсдөд нь шууд нөлөөлдөг үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, мэдлэг, чадвараа залуу үедээ өвлүүлэх,
- Тэдний сонирхол чадварт тохирсон сайн дурын үйл ажиллагаанд оролцох боломжтой байх,
- Ахмад настнуудад чиглэсэн нийгмийн хөдөлгөөн, байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх,

Хамгаалал

- Гэр бүлийн зүгээс асрамж хамгаалал авах
- Бие махбодь, сэтгэц, сэтгэл санааны амар тайван түвшинг хадгалах, туслах, өвчнөөс урьдчилан сэргийлэх зэрэг эрүүл мэндийн хамгаалал

¹⁰ Т.Амаржаргал, Н.Ариунтуяа. “Ахмад настантай ажиллах нийгмийн ажлын арга зүй”. УБ., 2010

- Тэдэнд хууль, эрх зүйн үйлчилгээ, зөвлөгөө өгөх
- Нийгмийн болон оюун санааны дэмжлэг үзүүлэх
- Суллагдан гараад очих, хүлээж авах гэр бүлгүй ахмад настай хоригдлыг ахмадын асрамжийн төвд байршуулахаар шийдсэн бол тэдний итгэл үнэмшил, хэрэгцээ, нэр хүндийг дээдэлж, өөрийн эрүүл мэндээ хамгаалах, шийдвэр гаргах эрхийг хүндлэх

Өөрийгөө хөгжүүлэх

- Өөрийн нөөц боломжоо бүрэн нээх боломжоор хангах
- Нийгэм, соёл, боловсрол, сэтгэл санааны дэмжлэгийг авах

Нэр төр

- Аливаа мөлжлөг, бие махбодь, сэтгэл санааны хүчирхийлэлгүй байх
- Нас хүйс, арьс өнгө, үндэс угсаа, өндөр настай, хөгжлийн бэрхшээл зэргээс үл хамааран шударгаар хүндлэгдэх, эдийн засгийн байдлаас үл хамааран эрх тэгш үнэлэгдэх зэрэг хүний эрхийн үндсэн шаардлагыг биелүүлэх.

Ахмадуудын үндсэн аж амьдралын баталгаа нь эдийн засгийн дэмжлэг. Хорих ял эдэлж байгаа ахмад настай хоригдолд тэтгэвэр, тэтгэмжийг бүрэн авах, нэрийн дансандаа хадгалах боломжийг бүрдүүлэх нь тухайн хоригдол суллагдан гараад орлоготой байх, амьдралын чанараа дээшлүүлэхэд бодитой хувь нэмэр болох юм.

Ахмадуудын эрүүл мэндийг хамгаалах, сайжруулахын тулд дэмжлэг үзүүлэх. Үүнд эрүүл мэндийн оношлогоо, эрүүл мэндийн боловсрол багтдаг.

Ахмадын төв болон хамгааллын үйлчилгээ: бие физиологийн хөгшрөлт, өвчин эмгэг, сэтгэцийн байдал зэргээс хамаарч өдөр тутмын амьдралын үйл явц, чадавх нь буурч дангаар аж байдлаа авч явахад бэрхшээл тохиолдсон үед үзүүлдэг үйлчилгээ юм. Үүнд ахмадуудыг байршуулахад чиглэгдсэн ахмадын сувилгаа, эмчилгээг багтаасан ахмадын асрамжийн төвүүд багтдаг.

Ахмад настны асрамжийн газар нь өндөр настнуудыг байнгын эсвэл түр хугацаагаар байрлуулдаг. Ихэвчлэн хөдөлгөөний чадвар тодорхой хэмжээгээр хязгаарлагдсан, харж хандах хүнгүй ганц бие, байнгын халамж шаардлагатай ахмадуудыг байрлуулдаг. Асрамжийн газарт ихэнхдээ эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг, мөн чөлөөт цагийг зохион байгуулах, нөхөн сэргээх, сэтгэл зүйн ач холбогдолтой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг. Мөн байранд амьдарч байгаа болон шинээр ирж байгаа ахмад настнуудад асрамжийн газрын талаар мэдээлэл өгөх, нийгэм, сэтгэл зүйн дасан зохицлын үйлчилгээ үзүүлдэг.¹¹

¹¹ Т.Амаржаргал, Н.Ариунтуяа “Ахмад настантай ажиллах нийгмийн ажлын арга зүй”. УБ., 2010

ДУГНЭЛТ, САНАЛ

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх байгууллага нь ШШГЕГ, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран гэмт хэрэг үйлдсэн ахмад настай хоригдлыг дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, тэднийг хуулиа сахин биелүүлдэг иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, хүмүүжлийн олон талт ажлыг амжилттай хэрэгжүүлсээр ирсэн.

Гэвч өнөөдөр бидэнд анхааран авч үзэх, шийдвэрлэвэл зохих хэд хэдэн асуудал байгаа нь алба хаагчид, ахмад настай хоригдол, суллагдан гарсан иргэдээс авсан судалгаа, кейс зэргээс харагдаж байна. Үүнд:

Ахмад настай хүний бие мах бодийн онцлог, тусгай хэрэгцээг харгалзан хорих ангийн орчин нөхцөлийг сайруулах. Тухайлбал ариун цэврийн өрөө, сургалтын орчин, нийтийн хоолны газар болон зөвшөөрөгдсөн газруудаар саадгүй явахад бэрхшээлгүй байх.

Хорих анги, албаны нийгмийн ажилтны аргачилсан заавар"-т ахмад настантай ажиллах арга зүй, аргачлалыг нарийвчлан тусгах.

Ахмад настай хоригдлын онцлог, хэрэгцээнд тохирсон сургалт, нийгмийн ажлын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх.

Ахмад настай хоригдлыг суллагдан гарсны дараах нийгмийн баталгааг гангахад анхаарч, хоригдол урьд тогтоолгосон тэтгэвэр, тэтгэмжээ үргэжлүүлэн авах, хуульд заасан болзол шаардлагыг хангасан тохиолдолд хуулиар тогтоосон тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаа алдалгүй шинээр тогтоолгоход нийгмийн ажилтан нар санал санаачлагатай хандах. Мөн Засгийн газраас олгож байгаа мөнгөн тэтгэмж, туслаж үйлчилгээнд бүрэн хамруулж, мэдээ мэдээллээр хангаж байх

Суллагдан гараад өөрийн гэсэн орон гэргүй, хүлээж авах хүнгүй өндөр настныг “Ахмад насны үндэсний төв”-д хүлээлгэн өгөхтэй холбоотой гарах зардал, бичиг баримт бүрдүүлэх, мэдээ мэдээллээр хангах зэрэг асуудлуудыг 2 байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд тодорхой дүрэм журмыг боловсруулан шийдвэрлэх.

Хорих байгууллагын алба хаагчид болон нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг ахмад настантай ажиллах арга зүй, мэдлэг чадварыг нэмэгдүүлж мэргэшүүлэх.

Ахмад настай хоригдлыг суллагдан гараад очиход асран хамгаалагчдад зориулсан сургалт, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх. Гэр бүлийн харилцаа холбоог сэргээхэд анхаарах. Суллагдан гарсаны дараа нийгмийн ажлын үйлчилгээг тасралтгүй үр дүнтэй явуулах, оршин суух сум хорооны хамтарсан багтай холбоотой ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

- [1]. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль
- [2]. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
- [3]. ШШГЕГ-ын 2022 оны 4 улирлын тоон мэдээ
- [4]. Т.Амаржаргал, Н.Ариунтуяа. “Ахмад настантай ажиллах нийгмийн ажлын арга зүй”
2010 УБ